



I-VI/2021

Тархаасан: 2021 оны 7 дугаар сарын 19



Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын мэдээллээр эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлого 2021 оны эхний хагас жилд 225.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 34.2 (17.9%) тэрбум төгрөгөөр нэмэгдэж, эрүүл мэндийн даатгалын сангийн тусламж, үйлчилгээний зардал 514.8 тэрбум төгрөг болж, 318.5 (2.6 дахин) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага*, төрлөөр, сая төгрөгөөр, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Үзүүлэлт	2020 I-VI	2021 I-VI	$\frac{2021 \text{ I-VI}}{2020 \text{ I-VI}}$ %
Эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлого	190 827.1	224 998.7	117.9
Даатгуулагчийн өөрөө хариуцан төлсөн шимтгэл	9 332.5	8 134.6	87.2
Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	6 362.6	5 817.0	91.4
Малчин	2 237.1	1 812.3	81.0
Их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн суралцагч	732.8	505.3	68.9
Ажил олгогч, даатгуулагчийн төлсөн	139 520.9	174 846.9	125.3
Төр даатгалыг нь хариуцах иргэдэд улсын төсвөөс төлсөн	41 973.7	42 017.2	100.1
Эрүүл мэндийн даатгалын сангийн тусламж үйлчилгээний зардал	195 955.3	514 487.7	262.6
Эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардал	167 910.3	479 003.2	285.3
Сувиллын тусламж үйлчилгээний зардал	6 956.9	2 786.3	40.1
Эмийн үнийн хөнгөлөлтийн зардал	21 088.1	32 698.3	155.1

* Урьдчилсан гүйцэтгэл

Эх үүсвэр: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар

Эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлого нэмэгдсэн нь ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэл 175.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 35.3 (25.3%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 2. Эрүүл мэндийн даатгалд хамрагдагчид, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	2020 VI	2021 VI	$\frac{2021 \text{ VI}}{2020 \text{ VI}}$ %
Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчид	3 155 969	3 272 200	103.7
Шимтгэлийг ажил олгогч, даатгуулагч хариуцан төлсөн иргэд	805 068	826 246	102.6
Төсөвт байгууллагын ажилтан	248 794	254 046	102.1
Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан	556 274	572 200	102.9
Шимтгэлийг өөрөө хариуцан төлсөн иргэд	184 390	137 677	74.7
Малчин	51 649	39 043	75.6
Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	115 644	88 369	76.4
Их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн суралцагч	16 975	10 139	59.7
Бусад даатгуулагч	122	126	103.3
Шимтгэлийг улсын төсвөөс хариуцсан иргэд	2 166 511	2 308 277	106.5

Тайлбар: ЭМД-д даатгуулагчид давхардсан тоогоор орсон болно.

Эх үүсвэр: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар

Улсын хэмжээнд 2021 оны 6 дугаар сард эрүүл мэндийн даатгалд давхардсан тоогоор 3.3 сая даатгуулагч хамрагдсаны 70.5 хувь нь шимтгэлийг улсын төсвөөс хариуцсан иргэд, 25.3 хувь нь шимтгэлийг ажил олгогч, даатгуулагч хариуцан төлсөн иргэд, 4.2 хувь нь шимтгэлийг өөрөө хариуцан төлсөн иргэд байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын мэдээллээр улсын хэмжээнд эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлдэг эмийн борлуулалт 2021 оны эхний хагас жилийн байдлаар 34.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 16.0 (86.8%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ оны 6 дугаар сард эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлдэг эмийн борлуулалт 6.0 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 80.5 (1.3%) сая төгрөгөөр буурсан байна.

Зүрх судасны эмийн борлуулалт 2021 оны эхний хагас жилд 16.1 тэрбум төгрөг болж, нийт борлуулалтын 46.6 хувийг эзэлж байна.

Хүснэгт 3. Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлдэг эмийн борлуулалт, хамгийн их борлуулалттай эмийн нэр төрлөөр, сая төгрөгөөр, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Үзүүлэлт	2020 I-VI	2021 I-VI	$\frac{2021 \text{ I-VI}}{2020 \text{ I-VI}}$ %
Дүн	18 471.0	34 496.5	186.8
Зүрх судасны эм	8 938.1	16 074.6	179.8
Халдварын эсрэг бэлдмэл	3 911.2	3 106.5	79.4
Ходоод, гэдэсний замын өвчнийг эмчлэх эм	1 822.1	5 394.3	296.0
Сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийг эмчлэх эм	1 737.5	2 761.9	159.0
Даавар, дааврын үйлдэлт бусад бэлдмэл ба жирэмслэлтээс сэргийлэх бэлдмэл	846.2	2 610.4	308.5
Бусад эм	1 215.9	4 548.8	374.1

Эх үүсвэр: ЭМДЕГ-ын захиргааны мэдээлэл

Улсын хэмжээнд 2021 оны эхний хагас жилд эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлдэг хамгийн их борлуулалттай 5 эмийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад халдварын эсрэг бэлдмэлийн эм 804.7 (20.6%) сая төгрөгөөр буурч, харин сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийг эмчлэх эм 1.0 (59.0%) тэрбум төгрөг, зүрх судасны эмийн борлуулалт 7.1 (79.8%) тэрбум төгрөг, даавар, дааврын үйлдэлт бусад бэлдмэл ба жирэмслэлтээс сэргийлэх бэлдмэл 1.8 (3.1 дахин) тэрбум төгрөг, ходоод гэдэсний замын өвчнийг эмчлэх эм 3.6 (3.0 дахин) тэрбум төгрөг, бусад төрлийн эмийн борлуулалт 3.3 (3.7 дахин) тэрбум төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Ойлголт, тодорхойлолт:

Эрүүл мэндийн даатгал: Төр, иргэн, хуулийн этгээдээс хуульд заасан журмын дагуу эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлж, эрүүл мэндийн даатгалын санг урьдчилан бүрдүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах үйл ажиллагааг хэлнэ.

Даатгуулагч: Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу эрүүл мэндийн даатгалын санд шимтгэл тогтмол урьдчилан төлж, эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ уг даатгалын сангаас хуваалцах эрх бүхий иргэнийг хэлнэ.

Бусад даатгуулагч: Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.9-т зааснаас бусад даатгуулагчид орно.

Шимтгэлийг улсын төсвөөс хариуцах иргэдэд 0-18 насны хүүхэд, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хүүхдээ асарч буй эх, эцэг, хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч, ял эдэлж буй ялтан орно.

Тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн: Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1-т заасан тэтгэвэр авагчид, Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1-т заасан иргэдийг хэлнэ.

Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн: Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 -д заасан Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүнийг хэлнэ.



Эх үүсвэр: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын мэдээ

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 8 дугаар сарын 16

Хүн ам, нийгмийн статистикийн
газрын дарга А.Амарбал
Утас : (976-51)-264805

Хүн ам, нийгмийн статистикийн газрын
статистикч М.Доржпагма
Утас : (976-51)-263966



@StatisticMongolia



@statistic_mn



information@nso.mn



Лавлах утас 1900-1212